



МОНГОС ТУСГАЙН ХӨВДӨЛ
1992 оны 08 дундвар сарын 18
№31 /652/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

173

Монгол Улсын Их
Хурлын тогтоол

177

Монгол Улсын
Төрийн газрын
тогтоол

183

**Олон хүүхэд төрүүлж өсгөсөн
эхийг урамшуулах тухай**

**Төрөөс өндөр технологийн аж
үйлдвэрийн талаар баримтлах
бодлого батлах тухай**

**Хөрөнгийн зах зээлийг
хөгжүүлэх зарим арга
хэмжээний тухай**



ГАРЧИГ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

263.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1169
264.	Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1172
265.	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1172
266.	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхнийг урамшуулах тухай	1173
267.	Хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай	1174
268.	Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1175
269.	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1175

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

270.	Монгол Улсын 2009 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай	Дугаар 33	1176
271.	Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай	Дугаар 34	1177
272.	Газрын тосны бүтээгдэхүүнийг худалдан борлуулах тухай	Дугаар 37	1182

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

273.	Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 115	1183
274.	Журам батлах тухай	Дугаар 119	1193
275.	Нийтлэг журам батлах тухай	Дугаар 119	1202

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 06 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:



1/3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалт:

"3.1.9."харилцагч санхүүгийн байгууллага" гэж санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагыг."

2/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

"12.2.Аж ахуйн нэгж, байгууллага нь улирал, жилийн санхүүгийн тайланг батлагдсан маягтаар болон цахим хэлбэрээр энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад тушаана."

3/15 дугаар зүйлийн 15.2.6, 15.2.7 дахь заалт:

"15.2.6.салбарын онцлогийг илэрхийлсэн нягтлан бодох бүртгэлийн журам, зааврыг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран батлах;

15.2.7.нягтлан бодох бүртгэл, хяналтын зарим чиг үүргийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр төрийн бус мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх."

4/ 15 дугаар зүйлийн 15.7- 15.9 дэх хэсэг:

"15.7.Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд нягтлан бодох бүртгэлийн стандартын орон тооны бус хороо байна.

15.8.Энэ хуулийн 15.7-д заасан хорооны дүрмийг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.9.Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогчийн дүрмийг Засгийн газар батална."

5/ 21 дүгээр зүйлийн 21.4, 21.5, 21.6 дахь хэсэг:

"21.4.Нягтлан бодох бүртгэлийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг улсын ерөнхий байцаагч олгоно.

21.5.Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч нь шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд шийтгэврийн хуудасны загварыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.6.Нягтлан бодох бүртгэлийн улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно."

6/ 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг:

"23.2. Санхүүгийн тайланг зургаа ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад тушаагаагүй



аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгох талаар нягтлан бодох бүртгэлийн улсын ерөнхий байцаагчийн саналыг үндэслэн бүртгэх байгууллага хэвлэлээр нийтэд зарлах бөгөөд зарласнаас хойш зургаан сарын дотор санал, гомдол гараагүй тохиолдолд улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгоно.”

2 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг:

“6.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, гүйлгээгээ нягтлан бодох бүртгэлд үндэсний мөнгөн тэмдэгт- төгрөг, мөнгөөр хөтөлнө.”

2/10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг:

“10.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад, төсөвт байгууллага нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн санхүүгийн тайлангаа гаргана.”

3/ 15 дугаар зүйлийн 15.2.4, 15.2.5 дахь заалт:

“15.2.4. нягтлан бодох бүртгэлийн программ хангамжид зөвшөөрөл олгох, хяналт тавих журмыг баталж, биелэлтэд нь хяналт тавих;

15.2.5. улсын хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн нэгтгэл хийх, санхүүгийн тайланг цахим хэлбэрээр тушаах, тэдгээртэй холбогдох мэдээллийг ашиглахтай холбогдсон журам баталж, судалгаа дүгнэлт гаргах.”

4/ 23 дугаар зүйлийн 23.1.1-23.1.3 дахь заалт:

“23.1.1. энэ хуулийн 8.3, 8.4, 12.2, 17.3, 17.4, 20.1-д заасныг зөрчсөн бол буруутай албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

23.1.2. аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийг хөтлөөгүй, санхүүгийн тайлан гаргаагүй бол холбогдох албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 2000000-5000000 хүртэл төгрөгөөр торгох;

23.1.3. санхүүгийн тайлангаа энэ хуулийн 13.2-13.4-т заасан хугацаанд тушаагаагүй албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний



доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.”

3 дугаар зүйл.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-12.4 дэх заалтын дугаарыг “12.3-12.5” болгон, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн дугаарыг “21.7.” болгон тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 06 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “Монголбанюнаас” гэснийг “санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монголбанюны хамтран” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 06 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “Санхүүгийн зохицуулах хорооноос ” гэснийг “санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах хорооны хамтран” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2010 оны 06 дугаар
сарын 25-ны өдөрУлаанбаатар
хот**ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН
ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ****1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг
урамшуулах тухай хууль тогтоомж**

2.1. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль тогтоомж нь Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай¹, Нийгмийн халамжийн тухай хууль², энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулийн үйлчлэлд дараахь эх хамаарна:
3.1.1 дөрвөн болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, энэ хуулийн 4.1.1, 4.1.2-г заасан нөхцөлийг хангасан эх;
3.1.2. шинээр “Эхийн алдар” одон авсан эх.

**4 дүгээр зүйл. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох
урамшуулал**

4.1. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг дараахь одонгоор шагнана:

4.1.1 зургаан хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг “Эхийн адар” нэгдүгээр зэргийн одонгоор;

4.1.2 дөрвөн хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонгоор;

4.2. Энэ хуулийн 4.1.1, 4.1.2-г заасан одон бүхий эхэд хуульд

¹Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай хууль- “Хууль, дүрэм, тогтоолын амлалт”-ийн 1997 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²Нийгмийн халамжийн тухай хууль- “Төрийн мэдээлэл” амлалтын 2006 оны 4 дугаарт нийтлэгдсэн.

заасан журмын дагуу мөнгөн тусламж олгоно.

5 дугаар зүйл. Бүрдүүлэх баримт бичиг

5.1. Энэ хуулийн 4.2-т заасан мөнгөн тусламж авах эх дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, дүүргийн халамж, үйлчилгээний байгууллага, эсхүл сумын нийгмийн ажилтанд өгнө.

5.1.1. "Эхийн алдар" нэгдүгээр зэргийн одонгийн, эсхүл "Эхийн алдар" хоёрдугаар зэргийн одонгийн үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

5.1.2. иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

5.1.3. мөнгөн тусламж авахыг хүссэн өргөдөл.

6 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

6.1. Энэ хуулийг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д. ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 06 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1957 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр баталсан Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг өргөтгөн нэмэгдүүлэх тухай хуулийн "8 ба түүнээс дээш хүүхэд төрүүлэн өсгөсөн эхэд "Эхийн алдар" нэгдүгээр зэргийн одон, 5-8 хүртэл хүүхэд төрүүлэн өсгөсөн эхэд "Эхийн алдар" хоёрдугаар зэргийн одонг шагналын хамт тус тус олгож байхаар тогтоосугай." гэсэн 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д. ДЭМБЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2010 оны 07 дугаар
сарын 01-ний өдөрУлаанбаатар
хот**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 16.1.11 дэх заалт нэмсүгэй:

"16.1.11.Бичил уурхайн зориулалтаар олгосон газар."

2 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн "сум" гэсний дараа ", дүүрж" гэж, "16.1.7" гэсний дараа ", 16.1.11" гэж тус тус нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА****Д.ДЭМБЭРЭЛ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2010 оны 07 дугаар
сарын 01-ний өдөрУлаанбаатар
хот**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь заалт:

"4.1.23."Бичил уурхай" гэж Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар олгосон ашигт малтмалын үйлдвэрлэлийн бус агуулгатай эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд, илрэл бүхий талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг."

2/11 дүгээр зүйлийн 11.1.23 дахь заалт:

"11.1.23.Энэ хуулийн 12.1.5-д заасны дагуу сум, дүүргийн Засаг даргын гаргасан хүсэлтийг хүлээн авч сонгосон газар нь ашигт малтмал эрх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан эсэх талаар дүгнэлт гаргаж, газрын хэмжээ, хил хязгаарыг тогтоох."

3/12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт:

"12.1.5.Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан



зориулалтаар олгохоор сонгосон газрын талаар энэ хуулийн 11.1.23-д заасан дүгнэлт гаргуулах тухай хүсэлтийг төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.”

4/66 дугаар зүйлийн 66.1.9 дахь заалт:

“66.1.9.бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг зөрчсөн иргэнийг 100000-300000 хүртэл, албан тушаалтныг 500000-1000000 хүртэл, хуулийн этгээдийг 1000000-2000000 хүртэл төгрөгөөр торгох.”

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.2.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг Засгийн газар батална.”

3 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “11.1.22” гэснийг “11.1.23” гэж, “7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрөлгүйгээр” гэснийг “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдөр баталсан Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 06 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

**Монгол Улсын 2009 оны төсвийн
гүйцэтгэлийг батлах тухай**

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Монгол Улсын 2009 оны төсвийн гүйцэтгэлийн орлогыг 1,431,875.4 /нэг их наяд, дөрвөн зуун гучин нэгэн тэрбум, найман зуун далан таван сая, дөрвөн зуун мянга/ сая төгрөгөөр, зарлагыг 1,746,616.9 /нэг их наяд, долоон зуун дөчин зургаан тэрбум, зургаан зуун арван зургаан сая, есөн зуун мянга/ сая төгрөгөөр тус тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 06 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого-ыг хавсралтаар баталсугай.

2. Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого-ыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан баталж, тухайн жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2010 оны
34 дугаар тогтоолын хавсралт

ТӨРӨӨС ӨНДӨР ТЕХНОЛОГИЙН АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Өндөр технологийн аж үйлдвэрийн салбар нь Монгол Улсын хөгжлийг эрчимжүүлэх, мэдлэгт суурилсан эдийн засгийн үндсийг тавих гол хүчин зүйлсийн нэг мөн.

1.2.Өндөр технологийн аж үйлдвэр гэдэгт инновацийн дэвшилтэт ололтыг нэвтрүүлэх замаар нэмүү өртөг ихээр шингээсэн бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг, тухайн бүтээгдэхүүний нийт өртөгт түүнийг бий болгоход зарцуулсан судалгаа, хөгжлийн зардал өндөр хувийг эзэлдэг эдийн засгийн салбарыг ойлгоно. Өндөр технологийн салбарт биотехнологи, нанотехнологи, мэдээллийн технологи, электроникийн салбар багтана.

1.3.Өндөр технологийн аж үйлдвэр нь Монгол Улсыг хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, уул уурхайн олборлох үйлдвэрлэлд түшиглэсэн эдийн засгаас тэргүүний, дэвшилтэт мэдлэг, технологид суурилсан мэдлэгийн эдийн засагт шилжүүлэх гарц, аж үйлдвэрийн төрөлжилтийг эрчимжүүлэн үндэсний баялгийг богино хугацаанд эрс нэмэгдүүлэх, улс орны өрсөлдөх



чадварыг дээшлүүлэх арга зам, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар бүхий үндэсний боловсрол, судалгаа хөгжил, технологи, аж үйлдвэр, санхүү, борлуулалтын сүлжээг бий болгох үндсэн хүчин зүйл хэмээн үзэж төрөөс онцгойлон дэмжэнэ.

1.4 Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого (цаашид "Бодлого" гэх) нь аж үйлдвэр, шинжлэх ухаан, технологи, инновацийн талаархи төрийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тэргүүний, дэвшилтэт технологид суурилсан өндөр технологийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд өндөр технологийн бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмэгдүүлэх, тэдгээрийг дотоод, гадаадын зах зээлд борлуулах үйл ажиллагааны эдийн засаг, эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэх цогц арга хэмжээг тодорхойлоход чиглэнэ.

Хоёр.Бодлогын зарчим

2.1 Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

2.1.1 үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, байгаль орчид сөрөг нөлөө үзүүлэх үйлдвэрлэл эрхлэхгүй байх;

2.1.2 экспортод чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тэргүүн ээлжинд дэмжин хөгжүүлэх;

2.1.3 төр, хувийн хэвшлийн үр ашгтай түншлэлд суурилах.

Гурав.Бодлогын зорилго

3.1 Бодлогын зорилго нь өндөр технологийн аж үйлдвэрийг үндэсний эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах үндсэн хүчин зүйлийн нэг болохуйц түвшинд хуртгал хөгжүүлэхэд оршино.

Дөрөв.Бодлогын чиглэл, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1 Бодлогыг дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

4.1.1 өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;

4.1.2 өндөр технологийн аж үйлдвэрийн дэд бүтцийг хөгжүүлэх;

4.1.3 өндөр технологийн аж үйлдвэрийн хүний нөөцийг бэлтгэх;

4.1.4 өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл,



борлуулалтыг дэмжих;

4.1.5.өндөр технологийн аж үйлдвэрийн санхүүжилтийн тогтолцоог төлөвшүүлэн хөгжүүлэх.

4.2.Бодлогын чиглэлийг хэрэгжүүлэх дараахь арга хэмжээг авна:

4.2.1.Өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр:

4.2.1.1.инноваци, инновацийн сан, венч хөрөнгө, шинжлэх ухааны паркийг хөгжүүлэх болон бусад эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

4.2.1.2.оюуны өмчийн эрхийн хамгаалалттай холбогдсон хууль, эрх зүйн баримт бичгийг хөгжингүй орнуудын жишигт нийцүүлэн боловсронгуй болгож хэрэгжилтийг зохион байгуулах;

4.2.1.3.өндөр технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх, хөрөнгө оруулалтыг татвараас чөлөөлөх, зээлийн баталгаа олгох эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

4.2.1.4.өндөр технологийн үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, урвалжийг гаалийн болон нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлөх, татварын зээл олгох, татварыг дараа тооцох эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

4.2.1.5.өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх үндэсний, салбарын, бүс нутгийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

4.2.1.6.өндөр технологийн аж үйлдвэрийн хөгжлийн түвшинг илэрхийлэх эдийн засгийн цогц үзүүлэлтийг боловсруулж, хяналт-шааржлал, үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх;

4.2.1.7.өндөр технологийн бүтээгдэхүүний зах зээл, хөгжлийн хандлагын судалгааг тогтмол явуулах.

4.2.2.Өндөр технологийн аж үйлдвэрийн дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр:

4.2.2.1.бүсчилсэн хөгжлийн стратегитай уялдуулан өндөр технологийн сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг цогцоор нь хэрэгжүүлэх, өндөр технологийн гарааны компаниудыг олноор нь дэмжин гаргах үүрэг бүхий шинжлэх ухааны паркуудыг байгуулж хөгжүүлэх;

4.2.2.2.орчин үеийн шаардлага хангасан судалгаа, хөгжлийн төв, барилга байгууламж, лабораторийн цогцолборыг олон улсын стандартын дагуу барьж байгуулах;

4.2.2.3.өндөр технологийн мэдлэгийг нийтэд хүртээх, түгээн дэлгэрүүлэх үүрэг бүхий мэдээллийн дэд бүтцийг байгуулж хөгжүүлэх.

4.2.3.Өндөр технологийн аж үйлдвэрийн хүний нооцийг



бэлтгэх чиглэлээр:

4.2.3.1.өндөр технологийн салбарын хүний нөөцийн бодлого, стратегийг боловсруулж хэрэгжүүлэх;

4.2.3.2.өндөр технологийн чиглэлээр магистрын болон докторын сургалтад суралцагчдыг тэтгэлэгт хөтөлбөрт тэргүүн зэлжэнд хамруулах;

4.2.3.3.өндөр технологийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компанийн захиалсан чиглэлийн дагуу Сургалтын төрийн сан, Инновацийн сангийн санхүүжилт, бусад тэтгэлгээр дэлхийн тэргүүлэх их сургуулиудад мэргэжилтэн бэлтгэх;

4.2.3.4.өндөр технологийн аж үйлдвэрийн салбарт шаардлагатай өндөр мэргэшсэн боловсон хүчнийг гадаадаас урьж ажиллуулах эрх зүй, эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.3.5.өндөр технологийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа дотоодын аж ахуйн нэгжийг, энэ чиглэлээр гадаадад сурч, ажиллаж байгаа монгол иргэдтэй холбоо тогтоох, хамтран ажиллах үйл ажиллагааг зохион байгуулж, гадаадад өндөр технологийн мэргэжлээр суралцаж төгсөгчдөд эх орондоо судалгаа, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь бүх талын дэмжлэг үзүүлэх;

4.2.3.6.өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, санхүүжилт, удирдлагын чиглэлээр боловсон хүчнийг гадаадын их сургуулиудад бэлтгэх, дотоодод сургалтын хөтөлбөр, арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

4.2.4.Өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих чиглэлээр:

4.2.4.1.өндөр технологийг аж ахуйн эргэлтэд оруулах үйл ажиллагаа явуулж байгаа шинжлэх ухааны байгууллага, аж ахуйн нэгжийн хоорондын хамтын ажиллагааг бүх талаар дэмжих;

4.2.4.2.өндөр технологи бий болгох, түүнийг ашиглах аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгох;

4.2.4.3.өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэхэд шаардлагатай үндэсний стандарт, хэмжил зүйг олон улсын норм, норматив, арга зүйн баримт бичгүүдтэй нийцүүлэн шинэчилж, өндөр технологийн бүтээгдэхүүний дотоодын болон олон улсын зах зээлд гаргах үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлж хөгжүүлэх;

4.2.4.4.өндөр технологийн салбарт олон улсын стандарт (GLP, GMP, GCP зэрэг)-ыг нэвтрүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

4.2.4.5.өндөр технологийн үйл ажиллагаанд оролцогчдын хамтын ажиллагааг дэмжих зорилгоор шинжлэх ухааны нээлт, шинэ мэдлэг, дэвшилтэт технологи, оюуны өмч, зах зээл, санхүү, бизнесийн чиглэлээр төрөлжсөн мэдээллийн сан байгуулах;



4.2.4.6. эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэл, борлуулалт, санхүүжилтээрээ дэлхийн зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэхүйц үндэстэн дамжсан үндэсний корпорацудыг үүсгэн байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх;

4.2.4.7. өндөр технологийн бүтээгдэхүүний дотоодын зах зээлийг хөгжүүлэх;

4.2.4.8. өндөр технологийн үйлдвэрлэлийн өндөр өртөгтэй тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээс /лизинг/-ээр авах боломжийг бүрдүүлэх;

4.2.4.9. өндөр технологийн салбарт амжилт гаргасан аж ахуйн нэгж, иргэдийн туршлагыг олон нийтэд сурталчлах, урамшуулах, үзэсгэлэн худалдаа тогтмол зохион байгуулах.

4.2.5. Өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх санхүүжилтийн тогтолцоог төлөвшүүлэн хөгжүүлэх чиглэлээр:

4.2.5.1. өндөр технологийн судалгаа шинжилгээнд зарцуулах улсын төсвийн хөрөнгийн хэмжээг жил бүр нэмэгдүүлэх;

4.2.5.2. өндөр технологийн үйл ажиллагааг хувийн болон төр, хувийн хэвшлийн хамтарсан хөрөнгө оруулалтаар дэмжих эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;

4.2.5.3. өндөр технологийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжид судалгаа боловсруулалт, бүтээгдэхүүний борлуулалт, маркетинг, дэд бүтцийн чиглэлээр Хөгжлийн банк болон Засгийн газрын тусгай сангаас хөрөнгө оруулалт хийх, хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжилт олгох эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

4.2.5.4. үндэсний компаниуд гадаадын өндөр технологийн компанийн үнэт цаас, технологийг худалдан авахад зориулж Засгийн газраас санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх;

4.2.5.5. өндөр технологийн аж үйлдвэрийн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих;

4.2.5.6. Венч хөрөнгийн санг төрийн дэмжлэгтэйгээр хөгжүүлж өндөр технологийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудыг хөрөнгө оруулалтаар дэмжих;

4.2.5.7. өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахад зориулж арилжааны банкнаас урт хугацааны, хөнгөлөлттэй зээл олгоход төрөөс дэмжлэг үзүүлэх;

4.2.5.8. олон улсын аудитын компаниар үнэлгээ хийлгэсэн өндөр технологийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компани хөрөнгийн зах зээлд шууд гарах боломжийг бүрдүүлж ажиллах;

4.2.5.9. өндөр технологийн компанийн төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх зорилгоор үндэсний компанид опцион зэрэг үнэт цаасны арилжаанд оролцох боломжийг бүрдүүлэх;

4.2.5.10. олон улсын хөрөнгийн зах зээлд гарч



байгаа үндэсний Венч хөрөнгийн санд Засгийн газар анхны хөрөнгө оруулагчийн үүрэгтэйгээр оролцох.

Таа.Бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн, түүний удирдлага, зохион байгуулалт

5.1.Бодлогыг амжилттай хэрэгжүүлснээр манай орны эдийн засгийн бүтэц сайжирч, дотоодын нийт бүтээгдэхүүнд өндөр технологийн аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жин нэмэгдэнэ.

5.2.Өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлснээр боловсруулах салбарын өндөр өсөлтийг ханган улс орны өрсөлдөх чадвар сайжирч дэлхийн эдийн засагт нэгдэн орох нөхцөл бүрдэнэ.

5.3.Оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулж үндэсний банкгийг нэмэгдүүлэх нөхцөл бий болно.

5.4.Өндөр технологийн салбарт оруулах хөрөнгө оруулалтын эрсдэл буурч, эдийн засгийн үр ашиг дээшилнэ.

5.5.Хүн амын амьдралын чанар сайжирч, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс суурь бий болж, үндэсний аюулгүй байдлын баталгаа нэмэгдэнэ.

5.6.Дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар бүхий үндэсний боловсрол, судалгаа хөгжил, технологи, аж үйлдвэр, санхүү, борлуултын сүлжээ бүрэлдэн хөгжиж мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих нөхцөл бүрдэнэ.

5.7.Бодлогын хэрэгжилтийг үндэсний хөгжил, шинэтгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 07 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 37

Улаанбаатар
хот

Газрын тосны бүтээгдэхүүнийг худалдан борлуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр нөөцөлсөн газрын тосны бүтээгдэхүүнийг худалдан борлуулж, орлогыг улсын төсөвт



төвлөрүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Баярсайхан/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 05 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 115

Улаанбаатар
хот

Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай

"Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын 2010 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 11 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Хавсралтад заасан арга хэмжээг дурдсан хугацаанд нь багтаан шуурхай хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагын удирдлагад, уг арга хэмжээний хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатарт тус тус даалгасугай.

3. Энэ тогтоолын хавсралтад заасан зарим арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг 2011 оны улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сэнгийн сайд С.Баярцогтод даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

мэдээлэл үргээж байгууллагын төлөө хүрдэгдэх ажиллагааны талаархи зохицуулалтыг нарийвчлэн тусгана

•Үндэт цаасны ажиллагаа, төлбөр, тусгаар, хадгалалт, хасварын үйлчилгээг үзүүлэх байгууллагын чиг үүрэгт нарийвчлан тодорхойлж, тэдгээрт таларгах санхүүгийн болон удирдлага, зохион байгуулалтын амардлага, харилцааны тодорхой болгож эдгээр хуулийн этгээдээс баглан мөрдөн дүрэм, журмыг тодорхойлон тусгана

•Үндэт цаас гаргагчийн үйл ажиллагааны ил тод байдалг дээшлүүлэх зорилгоор мэдээллийн урсгалын давтамж, мэдээллийн нягтад хүргэх журмыг шилжүүлнэ. Энэ ажил хуранд хөрөнгө оруулалтын зөвлөлийн үйл ажиллагааг хяргах хөдөлгөөн үйлчилгээний зохион байгуулалт, зохицуулалтын орныг нарийвчлан тогтооно

•Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор гууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас тэдгээрт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нэмэн төлүүлэх талаар нарийвчлсан журмыг тусгана

•Зах зээлийг ургуулан ажиллах, дотоод мэдээлэл ажиллах зорилгууль бус үйлдэлээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг илрүүлэх болон таслан зогсоохтой холбоотой зохицуулалтыг тусгана

•Хөрөнгийн зах зээлийн мөргөлийн холбооны эрх зүйн статус, чиг үүргийг газартай болгоно

•Олон улсын түвшинд бусад орны ажил төстэй чиг үүрэг бүхий үндэт цаасны зах зээлийн зохицуулалт байгууллагуудтай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцогдтой холбоотой Санхүүгийн



<p>Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах мөрдсөн институциональ хөрөнгө оруулагчдын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ</p>	<p>Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагааг зохицуулах тусгайлан зохиулах төсөл боловсруулна</p> <p>-Тусгаарын олон давхаргат тогтолцоо нэвтрүүлэхэд холбоотой урьдчилж дахиад буюу түүний тэтгэврийн хөнгөлбөр хэсгийг хөрөнгөтний хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ</p> <p>-Урсгал үнэт цаас (дериватив)-ыг хөрөнгийн зах зээлд худалдаагаар холбоотой үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бий болгоно</p> <p>-Хязгаарлагдмал харилцаагаар болон хуучинд компани болон гэрмийг тодорхой болгож хөрөнгийн бэрхдэ бүртгэлгүй болон хуучинд компани байх болох зохицуулалтыг тусгаж хөрөнгийн бэрхдэд эрсдэл багатай компанит бүртгэгдэх болох эрх зүйн орчныг бүрдүүлнэ</p>	<p>2011.07.01</p> <p>Саяагуурын зохицуулах хэрэг, Саяагийн аам, Хууль зүй, дотоод хэргийн аам, Нийслэлийн хамгаалал, Хэргийн хэргийн аам, Төрийн амын хэрэг</p>
<p>Компаний тусгай хуулийг шинэчлэн нэвтрүүлнэ</p>	<p>-Хуучинд компанийн хуучинд бүртгэлийг нэгдсэн байдлаар үнэт цаасны бүртгэлийн байгууллага гүйцэтгэх болно</p> <p>-Хуучинд компанийн захирт тусгай зайлшгүй хийхэд байх, уг хууль тусгай хуучинд салт, үйл ажиллагааны тайлан болон нэгдсэн ашиг хуваарилал эрх асуудлыг заавал хэлэлцэх болно</p> <p>-Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг нарийвчлан тусгаж төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний эрх зүйн статусыг тодорхой болгоно</p> <p>-Компани түүний удирдлага, эрх бүхий албан тушаалтныг тусгаж төлөөлөн удирдах зөвлөлийн талаарх зохицуулалтыг нарийвчлан тусгаж</p> <p>-Компаний эрх бүхий албан тушаалтныг</p>	<p>2010.07.01</p> <p>Төрийн амын хэрэг, Хууль зүй, дотоод хэргийн аам, Саяагуурын зохицуулах хэрэг</p>



	<p>картуудыг нэмэгдүүлж, компаний эрх ашгт нийцсэн шилбэр гаргах байх болсноы дүрү зарчмд сурьсан картуудыг зохицуулалтыг нэрийнхэн тусгаж</p> <p>-Хувиша эзэмшчид буруу, ташаа мэдээлэл өгсөн, зэрлэг үнэн зөв мэдээлэл өгөвөөс санаагай татгалзсан буюу хувиша эзэмшч эрхээ хэрэглүүлдэд нь санаатай саад хийсэн компаньийн эрх бүий албан тушаалтанд эд хөрөнгийн картуудыг хувишаа хувишаа эзэмшч картуудыг оруулсан корчөл суурьлалтаа нээжмэхлээ эрхтэй байх зохицуулалтыг нэрийнхэн тусгаж</p> <p>-Хувиша эзэмшчид хувишаа компаньийн үүргийн хөрөнхтэд хэнэлт тавьж, зохицуулах чиг үүрэг бүий төрийн байгууллага шаардлагатай гэм үзвэл итгэмжлүүлгээр хувишаа эзэмшчдийн эрх ашгтыг хамгаалаа тэдгээрдийн корчий өмчөөс шүүхэд нээжмэхлээ гаргах эрхтэй байгаар тусгаж</p> <p>-Хувишаа эзэмшчид тусгай компаньд эзэмшж байгаа хувишаа хэмжээ болон компаньийг төлөөлж итгэмжлэлтэй эхэлээ үн хамгааран эрх бүий албан тушаалтны буруутай үйл ажиллагааны талаар тусгай компаньийн корчий өмчөөс хувишаа эзэмшч шүүхэд нээжмэхлээ гаргах эрхтэй</p>	
	<p>Хувишаа эзэмшчид буруу, ташаа мэдээлэл өгсөн, зэрлэг үнэн зөв мэдээлэл өгөвөөс санаагай татгалзсан буюу хувишаа эзэмшч эрхээ хэрэглүүлдэд нь санаатай саад хийсэн компаньийн эрх бүий албан тушаалтанд эд хөрөнгийн картуудыг хувишаа хувишаа эзэмшч картуудыг оруулсан корчөл суурьлалтаа нээжмэхлээ эрхтэй байх зохицуулалтыг нэрийнхэн тусгаж</p> <p>-Хувишаа эзэмшчид хувишаа компаньийн үүргийн хөрөнхтэд хэнэлт тавьж, зохицуулах чиг үүрэг бүий төрийн байгууллага шаардлагатай гэм үзвэл итгэмжлүүлгээр хувишаа эзэмшчдийн эрх ашгтыг хамгаалаа тэдгээрдийн корчий өмчөөс шүүхэд нээжмэхлээ гаргах эрхтэй байгаар тусгаж</p> <p>-Хувишаа эзэмшчид тусгай компаньд эзэмшж байгаа хувишаа хэмжээ болон компаньийг төлөөлж итгэмжлэлтэй эхэлээ үн хамгааран эрх бүий албан тушаалтны буруутай үйл ажиллагааны талаар тусгай компаньийн корчий өмчөөс хувишаа эзэмшч шүүхэд нээжмэхлээ гаргах эрхтэй</p>	
5	<p>-Засгийн газрын болон орон нутгийн өрийн бөхийн эрх зүйн зохицуулалтыг нэрийнхэн тусгаж</p> <p>-Засгийн газрын өрийн бөхийн эрх зүйн зохицуулалтыг нэрийнхэн тусгаж</p>	<p>Засгийн газрын болон орон нутгийн өрийн бөхийн эрх зүйн зохицуулалтыг нэрийнхэн тусгаж</p> <p>Харангын бөхийн үйл ажиллагаанд мөрдөөг зурган, хүрмий болгохсонгуу болгоно</p>
	<p>Саягийн зам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын харангын бөж XX</p>	<p>2010.12.31</p> <p>2011.01.31</p>



	<p>Төвдөр тосгоор, төвлөрсөн хэдгэлэмжийн төв ХХК</p>
<p>орүүлэх, зуусгах, андэррайтлр, куульчын тосгоор, аглаах харууцлагыг харилцангай зохицуулна</p> <p>-Харегийн берийн палуунсэлтэйгээр үйл ажиллагаа явуулах хуулийн зүгээд, мэргэжилтэнд тавигдах нөхцөл шаардлага, шалгуур болон эмхэтгэл тогтоолоог тодорхой болгоно</p> <p>-Харегийн берийн зүгээс үндэц цаасны мергэлийн берийн бүртгэлд бүртгэхээс өмнө болон бүртгэхийн дараа тавих хяналт, шалгалт, зохицуулалтын чиг түүрийг харилцангай болгоно</p> <p>-Харегийн берээс харегца оруулагч болон олон нийтэд өгэх мэдээллийн төрөл, хэлбэр, давтамжийг харилцангай тогтоно</p> <p>-Харегийн зах зээлд үндэц, хэвч бодлогоор тэглэх, зах зээлийн харгах чадвар тогтоогруул байхад шаардлагатай дотлоод хяналт, зохицуулалт, тэмцэх технологийн шалгуур болон аргачлалтыг тодорхой болгоно</p>	<p>Төрийн өмчийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Мөнгөшлэв, Монголын аргегийн берг ХК, Үндэц цаасны төвдөр тосгоор, төвлөрсөн хэдгэлэмжийн төв ХХК</p>
<p>-Харегийн зах зээлд ажил, үнэмцгээ эргэлчид ёс-лон мөрдөл бс зүйн дурэм code of business code-с, стандартыг тогтоон мэдүүлнэ</p> <p>-Үндэц цаасны төвдөр, тосгооны тогтолоонд гарч байгаа эсрэгилэй бууруулж, бүтцийг олон улсын хяналт нөхцүлэн тодорхойлно</p> <p>-Үндэц цаасны нэгдсэн бүртгэлийн тогтолоор бий болгож, үндэц цаасны бүртгэлийн байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороо, улсын бүртгэлийн алба, тэтгэвэр алба зэрэг байгууллагын бүртгэлтэй холбоотой үйл ажиллагааны уялдаа холбоог дэхуулуно</p> <p>-Үндэц цаасны хэдгэлэмжийн үйл ажиллагаа эргэлч</p>	<p>2011.06.31</p>
<p>7. Үндэц цаасны төвдөр, тосгоор, хэдгэлэмж, өстөргөний үйл ажиллагаанда мөрдөл дурэм, журмыг гаргана</p>	



	<p>байгаа байгууллын чиг үүргийг тодорхой болгож, үндэт цаашиг өмчлөгчийн захиралыг үйлдвэрлэлээр хууль бусаар зарж буй эрхийг такстан зогсоож иргэд өөрсдөө хариуцаж байсан болон хэргийн байршил өөрчлөгдсөн байх тохиолдолд цаашиг замаар иргэд мөнгөн хөрөнгө хадгалуулсны төлөө хүү авдаг болгоно</p>		
	<p>-Үндэт цаашиг өмчлөгчийн үйлдвэрлэл эрхлэхийн байршил зогсоож байсан болон иргэд өөрсдөө хариуцаж байсан болон хэргийн байршил өөрчлөгдсөн байх тохиолдолд цаашиг замаар иргэд мөнгөн хөрөнгө хадгалуулсны төлөө хүү авдаг болгоно</p>	<p>-Аудит, үнэлгээ, зогсоох чадварын зэрэглэл тогтоох үйлчилгээг хараат бусад, мэргэжлийн өндөр түвшинд, харуулагчтайгаар үзүүлдэг болж, тэдгээрийн үйл ажиллагааг нийтэд нээлттэй болгож, итгэлээр зохио эрх зүйн актуалд нэмэлт оруулна</p>	<p>Аудит, үнэлгээ, зогсоох чадварын зэрэглэл чадварын зэрэглэл тогтоох үйл ажиллагааг харуулагчтайгаар үзүүлдэг болж, итгэлээр зохио эрх зүйн актуалд нэмэлт оруулна</p>
8	<p>Аудит, үнэлгээ, зогсоох чадварын зэрэглэл тогтоох үйлчилгээг харуулагчтайгаар үзүүлдэг болж, итгэлээр зохио эрх зүйн актуалд нэмэлт оруулна</p>	<p>-Аудит, үнэлгээ, зогсоох чадварын зэрэглэл тогтоох үйл ажиллагааг харуулагчтайгаар үзүүлдэг болж, итгэлээр зохио эрх зүйн актуалд нэмэлт оруулна</p>	<p>2011.06.31</p> <p>Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Монголын иргэдийн Бүжэг ХК, мэргэжлийн холбоод</p>
9	<p>Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэх байгаа хувийн эзтэд дамжуулсан, төлбөрийн чадаргүй болсон төлөвлөлдөх үйлдвэр ажиллагааны эрх зүйн орныг боловсруулж болгоно</p>	<p>-Дамжуулалтын тухай хуулийг шинэчлэн боловсруулна</p>	<p>2011.10.01</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн яам, Санхүүгийн зохицуулах хороо</p>

10	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн дагуу батлан гаргах шаардлагатай дараа журмыг батална	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны эрх зүй, хэргийн гэрээний цогц орчин бүрдэнэ	Санхүүгийн зохицуулах хороо, Монголын өртөөгийн корпорацийг ХХК	2010.12.31
Хойр Зохион байгуулалтын чиглэлээр анх эргэлтүүлэх эрх хэмээхээр үргэлжлэн				
1	Хөрөнгийн биржийн үйлдвэрийн бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагааны зарчмыг тодорхой болгоно	Хөрөнгийн биржийн үйлдвэрийг хараат бус, мөргөлдсөн, зах зээлийн болон нөхцөлийн эрх ашгийг эрх тэгш хангаж ажилладаг болно	Төрийн өмчийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХХ-ийн Төлөөлөн үйлдвэр эвчлэн	2010.10.01
2	Хөрөнгийн биржийн гүйцэтгэх үйлдвэрийн эргэлтүүлэгч үйл ажиллагааны хэрэг, чиг үүрэг, тодорхой болгож, тортмол хэмжээ, үнэлэх, тогтооног нөхцөлүүдийг	"Төлөөлөн үйлдвэр эвчлэлийн чиг үүрэг" нэмэгдүүлж, компанийн гүйцэтгэх үйлдвэрийг харуулахаар, үр өгөөжтэй ажиллах орчин бүрдүүлнэ	Төрийн өмчийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХХ-ийн Төлөөлөн үйлдвэр эвчлэн	2010.10.01
3	Хөрөнгийн биржийн бүртгэлийн шаардлагыг шийдсэн тооцоо, бүртгэлийг шийдсэн гүйцэтгэх хууль бусад компанийн алдагдалд оруулсан, дангуураа байдалд киргэсэн эрх бүхий албан тушаалтнуудад харьцангуй тооцоо	Хөрөнгө оруулалтын шаардлага хангагч, чанаргүй үнэт цаасны хэргийг, зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлнэ	Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо, Монголын хөрөнгийн бирж ХХ, Цагдаагийн ерөнхий газар	2010.12.31
4	Дансаа нээхгүй хувицаа эзэмшгчдийн асуудлыг шийдэх, зах зээлийн хөрвөх чадварыг дэмжих эрх хэмээх арга	Дансаа нээхгүй хувицаа гарга хувицааг тусгай санд төвлөрүүлж хөрвөх оруулалтын менежментийг мэргэжлийн байгууллагад шилжүүлэх боломжийг судална	Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны тасвар тооцоо, Төвлөрөн хадгалалтын тас ХХК, Монголын хөрөнгийн бирж ХХ	2011.12.31

<p>5</p> <p>Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлж байгаа хуулийн этгээдэд тавигдаж шаардлага, санхүүгийн чадварийн шаардлыг шинэчлэн тогтооно</p>	<p>-Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлж байгаа байгууллын санхүү, хувий нөөцийн чадварыг нэмэгдэнэ</p> <p>-Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлж байгаа байгууллагын үйл ажиллагааны үндэс бусдад учир болж эрсдэл буурч, үйл ажиллагааны чанар, цэр хурца нэмэгдэнэ</p>	<p>Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн бэрж XX</p>	<p>2011.01.31</p>
<p>6</p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны нутагд Хөрөнгийн бэржийн аргачлалд бодит шалт нь хяналт тавих боломж бүхий мэдээллийн технологийн програмыг хангамжийг бий болгож, Үнэт цаасны төлбөр тосгоо, төвлөрсөн кадриалажийн төв, ХХК-ийн сүлжээтэй холбоно</p> <p>Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлж байгаа хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсын нэгтгэл бодж бүртгэлийн стандартыг нэвтрүүлнэ</p>	<p>-Үнэт цаасны аргачлалыг бодит хяналт сайжурч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг шуудтай хамгаалах чадварыг, боломж нэмэгдэнэ</p> <p>-Санхүүгийн зохицуулах хороо болон Мөнгөний хөрөнгийн бэрж XX, Үнэт цаасны төлбөр тосгоо, төвлөрсөн кадриалажийн төв ХХК хоорондын ахсын уялдаа холбоо сайжурна</p>	<p>Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн бэрж XX</p>	<p>2011.12.31</p>
<p>7</p> <p>Бизнесийн болон хөрөнгийн үйлчилгээний аргачлалыг боловсруулж болгож, тухайн үйлчилгээг хуульч байгаа ах ахуйн нэгжийн чадварыг дээшлүүлнэ</p>	<p>•Олон улсын нэгтгэл жишээ, зарчмын дагуу нэгтгэл бодж бүртгэл хийгдэж, шаардлагатай подрауулыг хэрэглэж эхэлнэ</p>	<p>Санхүүгийн зах зээлд мэргэжлийн зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо Мөнгөний хөрөнгийн бэрж XX, мэргэжлийн холбоод</p>	<p>2011.06.31</p>
<p>8</p> <p>Мэргэжлийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа аргачлалыг олон улсын жишээтэй нэгдүүлнэ</p> <p>•Уул уурхайн салбарт ашигт малтмалын ордын үнэлгээг подрауулыг олон улсын аргачлал, стандартыг нэвтрүүлнэ</p>	<p>Санхүүгийн зах зээлд мэргэжлийн зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо, Стандартчилал, хэмжил зүйн газар, Мэргэжлийн хөдөлгөөн өргөний газар, Мөнгөний хөрөнгийн бэрж XX, мэргэжлийн холбоод</p>	<p>Санхүүгийн зах зээлд мэргэжлийн зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо, Стандартчилал, хэмжил зүйн газар, Мэргэжлийн хөдөлгөөн өргөний газар, Мөнгөний хөрөнгийн бэрж XX, мэргэжлийн холбоод</p>	<p>2011.06.01</p>



<p>9</p> <p>Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд болон хувьцаат компанийн талаархи мэдээллийн урсгалыг сайжруулж, мэдээллийн шилж бөгөөд бодитой байдлыг дээшлүүлнэ</p>	<p>-Хуулийн этгээдийн урсгал бүртгэл, талвар төлөгчийн бүртгэл, Санхүүгийн зохицуулах хорооны үндэт шашны бүртгэл, мэдээлэл, хөрөнгийн бирж болон үндэт шашны талбар тооцоо, хэдгэлэмжийн байгууллагын хувьцаачин бүртгэл, мэдээлэл, эд хөрөнгийн бүртгэл, мэргэжлийн холбооны бүртгэл, зээлийн мэдээллийн сан, Төрийн өмчийн хорооны бүртгэл болоод компанийн дотоод бүртгэл мэдээллийн зөрүүг арилгах, харилцан урсгалтай байх зэвсгэн байгууллагын арга хэмжээ явца</p> <p>-Компанийн үндэслэл, төмөрлөн хувиараа зохиогчийн хэргүүдэд ажиллуу</p> <p>-Хөрөнгийн зах зээлийн эрхчилж ажиллуулах, гэм буруутай этгээдийг шуурхай тогтоож, бусдад учруулсан хохирлыг бүрэн барагдуулах мэдээллийг бүтээгүүнэ</p> <p>-Цагдаа, прокурорын байгууллагын цагдааийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ</p> <p>-Банк орсон санхүүгийн нэгдэл, эхлэл байснаас бусад санхүүгийн байгууллага оролцсон нэгдлийн санхүүгийн нэгдсэн талсан, хяналтын аргачлал, тогтоолыг бий болгоно</p>	<p>улсын бүртгэлийн ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Төрийн өмчийн хороо, Мөнгөний хөрөнгийн бирж ХХ</p> <p>2011.12.31</p>
<p>10</p> <p>Цагдаа, прокурорын байгууллагын үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны хяналтын чиг үүрэгт итгэж холбож хяналт, шалгалтын ажилыг шуурхай байдлыг дээшлүүлнэ</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо</p>	<p>2010.12.31</p>
<p>11</p> <p>Санхүүгийн нэгдсэн хяналт, шалгалтын арга, аргачлалыг нэвдэрэй болгоно</p>	<p>Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо</p>	<p>2010.12.31</p>
<p>12</p> <p>Санхүүгийн зах зээлд хэрэглэж байгаа нэр томъёог жиг мөр болгоно</p>	<p>Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо, Монголбанк, Мөнгөний хөрөнгийн бирж ХХ, Үндэт шашны талбар тооцоо, төвлөрсөн хэдгэлэмжийн төв ХХК, мэргэжлийн холбоод</p>	<p>2010.10.01</p>

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2010 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 119

Улаанбаатар
хот**Журам батлах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Тогтоолыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай:

а) захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлийг 2011 онд багтаан шинэчлэх;

б) тогтоолын хэрэгжилтийн талаар жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байх;

в) захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын тухай хуулийн төслийг боловсруулан 2011 оны I улиралд Засгийн газарт оруулах.

4. Бүтэц, орон тооны хязгаартаа багтаан хууль зүйн асуудал хариуцсан нэгж буюу мэргэжилтэн ажиллуулах асуудлыг судалж шийдвэрлэхийг Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгасугай.

5. Энэхүү тогтоолоор баталсан журмыг захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахдаа дагаж мөрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Улсын Их Хурлаас байгуулсан төрийн байгууллага, төрийн бус байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 8 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД****С.БАТБОЛД****ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД****Ц.НЯМДОРЖ**

Монгол Улсын Засгийн газрын 2010
оны 119 дүгээр тогтоолын хавсралт

**ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООСОН
ШИЙДВЭР ГАРГАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25.1, 29.2, 39.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4 дэх хэсгийн биелэлтийг хангах арга ажиллагааны журмыг тогтооход оршино.

1.2. Энэхүү журмыг эрх бүхий этгээдээс гаргах захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг боловсруулах, батлах, түүнийг хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас хянах, бүртгэх, нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд мөрдөнө.

1.3. Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг эрх бүхий этгээд нь зөвхөн хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд гаргана.

1.4. Хуулиар тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг бүртгэхгүй бөгөөд ийм шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй.

1.5. Хуульд зааснаас бусад тохиолдолд эрх бүхий этгээд нь захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах эрхээ доод шатны байгууллага, албан тушаалтанд шилжүүлж болохгүй.

1.6. Энэ журамд заасан дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.6.1. "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр" гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон этгээдийн заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй, гадагш чиглэсэн шийдвэрийг;

1.6.2. "Хуулиар тусгайлан эрх олгогдсон" гэж хуульд заасан тухайлсан асуудлаар нийтээр дагаж биелүүлэх журам тогтоохыг үүрэг болгож, эрх олгосныг;

1.6.3. "Эрх бүхий этгээд" гэж Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга болон хуулиар хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахаар тусгайлан эрх олгогдсон газар, зөвлөл, хороо, төв, хүрээлэн зэрэг байгууллагыг;

1.6.4. "Гадагш чиглэсэн" гэж тухайн байгууллагын дотоод зохицуулалтын шинжийг агуулаагүй, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас заавал дагаж мөрдөхөөр журамласныг;

1.6.5. "Нөлөөллийн шинжилгээ" гэж тухайн шийдвэрийн нийгэм, эдийн засгийн амьдралд үзүүлэх үр нөлөө, үр дагаврыг урьдчилан судалж, тооцоолох цогц үйл ажиллагааг.

1.7. Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр /цаашид "шийдвэр" гэж нь дараахь шаардлагыг хангасан байна.

1.7.1. Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Улсын Их Хурлын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрт нийцсэн байх;

1.7.2. Тэмдэглэх хэсэгт үндэслэл болгож байгаа хуулийн заалтыг заавал дурдсан байх;

1.7.3. хуулиар тусгайлан олгогдсон эрх хэмжээнд нийцэж байх;

1.7.4. хууль тогтоомжийн зүйл, заалтыг хуулбарлан давхардуулаагүй байх, шаардлагатай гэж үзвэл ишлэл хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;

1.7.5. шийдвэрийн заалт нь хоорондоо болон эрх бүхий бусад этгээдийн гаргасан шийдвэрийн заалттай зөрчилдөхгүй байх;

1.7.6. хуульд заагаагүй үүргийг шинээр бий болгохгүй байх;

1.7.7. хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх;

1.7.8. шийдвэрийг батлан гаргасан байгууллага, албан тушаалтны болон шийдвэрийн нэр, огноо, дугаарыг тодорхой заасан байх;

1.7.9. Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэх;

1.7.10. хэл найруулга нь товч тодорхой, монгол хэлний зөв бичих дүрмийн дагуу хоёрдмол утгагүй, ойлгоход хялбар байдлаар бичигдсэн, "Албан хэрэг хотлолтийн үндсэн заавар"-т заасан баримт бичиг зохион бүрдүүлэх шаардлагыг хангасан байх;

1.7.11. тухайн шийдвэрээр урьд нь гарсан шийдвэрийг хүчингүй болсонд тооцож байгаа, эсхүл түүнд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа бол энэ тухай заалтыг заавал тусгасан байх.

1.8. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 3.1.2-г заасан баримт бичиг энэхүү журамд хамаарахгүй.

1.9. Шийдвэрийг хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хянаж, бүртгэнэ.

Хоёр. Шийдвэр гаргах ажиллагаа

2.1. Хуулиар тусгайлан эрх олгогдсон эрх бүхий этгээд дараахь тохиолдолд нэн даруй шийдвэр гаргана:

2.1.1. тухайн харилцааг зохицуулах хууль шинээр батлагдан гарсан, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан, хууль хүчингүй болсон;

2.1.2 гамшгаас хамгаалах болон гамшиг тохиолдсон үед яаралтай арга хэмжээ авах шаардлага гарсан;

2.1.3. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, ерөнхий бүдүүвч өөрчлөгдсөнөөс урьд нь үйлчилж байсан шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарсан.

2.2. Шийдвэр гаргах ажиллагаа нь дараахь үе шаттай байна.

2.2.1. шийдвэрийн төслийг бэлтгэх, батлах;

2.2.2. хянах, бүртгэх;

2.2.3. нийтэд мэдээлэх, хүчин төгөлдөр болох.

2.3. Шийдвэрийн төслийг бэлтгэх, батлах ажиллагаа:

2.3.1. Шийдвэрийн төсөл бэлтгэх ажиллагааг эрх бүхий этгээд удирдан зохион байгуулна;

2.3.2. Шийдвэрийн төсөл нь тодорхой байгууллага, албан тушаалтны эрхлэх асуудалд хамаарч байгаа бол тэдгээрээс албан ёсоор санал авсан байна;

2.3.3. Шийдвэрийн төслийг бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийж, түүнд дараахь нөхцөл байдлыг тусгаж, танилцуулга бэлтгэнэ:

а/ шийдвэр гаргах үндэслэл, шаардлага;

б/ шийдвэрийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ;

в/ шийдвэр гарсны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөж болохуйц бүлгийг тодорхойлох;

г/ хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх;

д/ тухайн асуудлыг зохицуулж байгаа урьд нь батлагдсан шийдвэр байгаа эсэх;

е/ шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүү, эдийн засгийн тооцоо.

2.3.4. Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлалыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална;

2.3.5. Шийдвэрийн төслийг байгууллагын цахим хуудаст 30-аас доошгүй хоног байрлуулж, санал авна;

2.3.6. Шийдвэрийн төсөлд олон нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж болно.

2.3.6.1. Хэлэлцүүлгийг дараахь хүрээнд явуулна:

а/ эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд;

б/ эрдэмтэн, судлаач, шинжээч зэрэг мэргэшсэн

хүрээнд;

- в/ тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд;
 - г/ төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд.
- 2.3.6.2. Хэлэлцүүлгийг дараахь хэлбэрээр зохион

байгуулна:

- а/ уулзалт, ярилцлага зохион байгуулах;
- б/ өдөр тутмын хэвлэлд шийдвэрийн төслийг нийтэлж

санал авах;

- в/ албан ёсны цахим хуудас, харилцаа холбооны хэрэгслээр санал авах;
- г/ бусад.

2.3.7. Хэлэлцүүлгийн явц үр дүнгийн талаар тэмдэглэл хөтөлж хэлэлцүүлгийн үеэр гарсан саналыг шийдвэрийн төсөлд хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэнэ;

2.3.8. Шийдвэрийн төслийг нөлөөллийн шинжилгээний танилцуулга болон хэлэлцүүлгийн мэдээллийн хамт тухайн байгууллагын хууль зүйн асуудал хариуцсан нэгж /газар, хэлтэс/, мэргэжилтнээр заавал хянуулна;

2.3.9. Эрх бүхий этгээд нь шийдвэрийг баталснаас хойш ажлын арван едрийн дотор хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ;

2.3.10. Хянуулж, бүртгүүлэх ажлыг эрх бүхий этгээдийн хууль зүйн асуудал хариуцсан нэгж /газар, хэлтэс/, мэргэжилтэн эрхлэн гүйцэтгэнэ.

2.4. Шийдвэрийг хүлээн авах, хянах, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх.

2.4.1. Эрх бүхий этгээд шийдвэрээ хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, бүртгүүлэхдээ дор дурдсан бүрдлийг хангасан байна:

- а/ эрх бүхий этгээд дангаар баталсан бол шийдвэрийн гурван хувь (албан ёсны эх хувь, түүний баталгаажуулсан хуулбарын хоёр хувь), цахим хувилбар, нөлөөллийн шинжилгээний танилцуулга, хэлэлцүүлгийн мэдээлэл;

- б/ эрх бүхий этгээдүүд шийдвэрийг хамтран баталсан бол тухайн шийдвэрт нэр нь эхэлж бичигдсэн албан тушаалтан хариуцан энэхүү заалтын "а"-д заасан бүрдлээс гадна хамтран баталсан бусад эрх бүхий этгээдийн тоогоор шийдвэрийн баталгаажуулсан хуулбар;

- в/ шийдвэрийг энэхүү журмын 1.6.3-т зааснаас бусад байгууллага, албан тушаалтантай хамтран баталсан тохиолдолд эрх бүхий этгээд нь энэ заалтын "а"-д заасны дагуу хүргүүлнэ.

2.4.2. Шийдвэрийг хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлж байгаа этгээд нь энэхүү журмын 2.4.1-д заасан материалын бүрдлийг хангаагүй тохиолдолд хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны



төв байгууллага хүлээн авахаас татгалзаж, бүрдлийг хангуулахаар албан бичгээр буцаана;

2.4.3. Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь 2.4.1-д заасны дагуу хүргүүлсэн шийдвэр, холбогдох материалыг ажлын арван өдрийн дотор хянаж, дараахь арга хэмжээний аль нэгийг авна:

а/ шийдвэр нь энэхүү журмын 1.7-д заасан шаардлагыг хангаж байгаа бол шийдвэрийн албан ёсны эх хувь дээр улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн тухай тусгай тэмдэглэл хийж баталгаажуулан, шийдвэрийн улсын нэгдсэн санд авна. Бүртгэсэн тухай албан бичиг болон улсын бүртгэлийн дугаар олгож тэмдэглэл хийсэн шийдвэрийн баталгаажуулсан хуулбарыг тухайн эрх бүхий этгээдэд, хамтарч баталсан бол бүх этгээдэд хүргүүлэх;

б/ шийдвэр нь бүхэлдээ буюу түүний аль нэг заалт нь энэ журмын 1.7-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд уг зөрчлийг арилгуулах тухай тодорхой үндэслэл, тайлбар бүхий дүгнэлт гаргаж, албан бичгээр хүргүүлэх;

в/ хэм хэмжээ тогтоогоогүй шийдвэр ирүүлсэн тохиолдолд улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх шаардлагагүй тухай хариу мэдэгдэж буцаан хүргүүлэх.

2.4.4. Энэ журмын 2.4.3-ын "а", "в"-д заасан арга хэмжээг хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргын, журмын 2.4.3-ын "б"-д заасан арга хэмжээг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний албан бичгээр тус тус мэдэгдэнэ.

2.4.5. Шийдвэр нь холбогдох хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа тухай хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дүгнэлтийг хүлээн авсан эрх бүхий этгээд өөрийн гаргасан шийдвэрийнхээ хууль зүйн үндэслэлийг хянан үзэж, түүнийг хүчингүй болгосон, эсхүл зохих нэмэлт, өөрчлөлт оруулсан бол энэ тухай ажлын арван өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ. Нэмэлт, өөрчлөлт оруулсан шийдвэрийг хянуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхдээ энэхүү журмын 2.4.1-д заасан бүрдлийг хангасан байна;

2.4.6. Эрх бүхий этгээд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дүгнэлтийг хүлээн авах үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ажлын арван өдрийн дотор албан бичгээр хариу мэдэгдэнэ;

2.4.7. Энэ журмын 2.4.5-д заасан хугацаанд хариу мэдэгдээгүй, эсхүл 2.4.6-д заасан хариуг хүлээж авах үндэслэлгүй гэж үзвэл хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дүгнэлт гарган ажлын 5 өдрийн дотор Засгийн газарт оруулж, эцэслэн шийдвэрлүүлнэ.

2.5. Шийдвэрийг нийтэд мэдээлэх, хүчин төгөлдөр болох:

2.5.1. Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны



төв байгууллага улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн шийдвэрийг бүртгэсэн өдрөөс хойш 10 хоногийн дотор "Хууль зүйн мэдээлэл" сэтгүүлд бүрэн эхээр нь нийтлүүлнэ;

2.5.2. Шийдвэрийг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Хууль зүйн мэдээлэл" сэтгүүлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ. Энэ шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж үзэж тухайн шийдвэрийг биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хариуцлага хүлээлгэхгүй;

2.5.3. Хүчин төгөлдөр бус шийдвэрийг дагаж мөрдүүлснээс үүсэх үр дагаврыг шийдвэр гаргасан эрх бүхий этгээд хариуцна;

2.5.4. Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн, хүчин төгөлдөр болсон шийдвэрийг бүрэн эхээр нь эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /www.legalinfo.mn цахим хуудас/ болон баталсан байгууллагын цахим хуудсанд тус тус байршуулна;

2.5.5. Шийдвэрийг үндэслэл болгох, хэсэгчлэн нийтлэх болон байгууллагын албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулахдаа улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн огноо, дугаарыг заавал дурдана.

2.6. Шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох:

2.6.1. Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан болон хүчингүй болсонд тооцсон тохиолдолд уг шийдвэрийг энэхүү журмын дагуу хянуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ;

2.6.2. Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн шийдвэрийг шүүх хүчингүй болгосон бол эрх бүхий этгээд энэ тухай албан бичгийг хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийн /магадлал, тогтоол/ хуулбарын хамт хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ажлын 3 өдрийн дотор хүргүүлнэ.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

3.1. Эрх бүхий этгээд нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа шийдвэрт жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, энэ тухай тайланг цаашид авах арга хэмжээний талаархи саналын хамт хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.2. Эрх бүхий этгээдийн энэхүү журмын 3.1-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

3.3. Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь эрх бүхий этгээдээс ирүүлсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, төлөвлөгөө, саналыг нэгтгэн судалж, цаашид авах арга хэмжээний талаархи саналаа Засгийн газарт танилцуулна.



3.4. Улсын нэгдсэн санд бүртгэлтэй боловч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид өөрчлөлт орсны улмаас эрхлэн хариуцах байгууллага нь тодорхойгүй болсон шийдвэрийг хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын хуралдаанд танилцуулж, эцэслэн шийдвэрлүүлнэ.

3.5. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид өөрчлөлт орсон тохиолдолд хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага холбогдох байгууллагатай хамтран тухайн салбарт мөрдөгдөж байгаа шийдвэрийн талаар ийнхүү өөрчлөлт хийгдсэнээс хойш 6 сарын дотор шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.6. Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь тодорхой салбарыг сонгон эрх бүхий этгээдийн шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж болно.

3.7. Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу шийдвэрийг хянаж, шаардлагатай арга хэмжээ авна.

Дөрөв. Тусгай зохицуулалт

4.1. Гамшгаас хамгаалах болон гамшиг тохиолдсон үед гаргасан шийдвэр нь нийтэд мэдээлсэнээр хүчин төгөлдөр болно.

4.2. Эрх бүхий этгээд энэ журмын 4.1-д заасны дагуу гаргасан шийдвэрээ гарсан өдрөөс нь хойш ажлын 3 өдрийн дотор хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.3. Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь шийдвэрийг хүлээн авснаас хойш түүнийг бүрэн эхээр нь эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ www.legalinfo.mn цахим хуудас/нд ажлын нэг өдөрт багтаан байршуулж, энэхүү журмын 2.5.1-д заасны дагуу "Хууль зүйн мэдээлэл" сэтгүүлд нийтлүүлнэ.

Тав. Бусад асуудал

5.1. Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн сан нь улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн шийдвэр, энэхүү журмын 4, 6 дугаар бүлэгт заасны дагуу хүлээн авсан шийдвэрээс бүрдэнэ. Нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.2. Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь нэгдсэн санд байгаа хүчин төгөлдөр шийдвэрийн жагсаалтыг шинэчлэн "Хууль зүйн мэдээлэл" сэтгүүлд жил бүрийн 2 дугаар



сарын 1-ний дотор нийтлүүлж байна.

5.3. Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас дугаар олгон тэмдэглэл хийж хүргүүлсэн шийдвэрийн хувийг эрх бүхий этгээд сан бүрдүүлэн хадгалж, иргэн, хуулийн этгээдийг зохих мэдээллээр хангана.

5.4. Сум, дүүргийн Засаг дарга нь гаргасан шийдвэрээ ажлын 10 өдрийн дотор дээд шатны Засаг даргаараа дамжуулан хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Онцлог зохицуулалт

6.1. Шийдвэрийн улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх, нийтэд мэдээлэл, лавлагаа өгөх зорилгоор иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Улсын Их Хурлаас байгуулдаг төрийн байгууллага, төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр гүйцэтгэдэг төрийн байгууллагаас гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг энэ журамд заасан хугацаанд хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хүлээн авч, шийдвэр нь хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа тохиолдолд тухайн байгууллагад зөвлөмж хүргүүлж болно.

6.2. Энэ журмын 6.1-д заасан этгээд нь зөвлөмжийг хүлээн авсан эсэх тухайгаа хариу мэдэгдэнэ.

6.3. Энэ журмын 6.1-д заасан этгээдийн шийдвэр нь захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт тавигдах шаардлагыг хангасан байвал зохино.

6.4. Энэ журмын 6.1-д заасан этгээд нь гаргасан шийдвэртээ нөлөөллийн шалгахыг хийсэн байна.

6.5. Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь шийдвэрийг хүлээн авснаас хойш, түүнийг бүрэн эхээр нь эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ /www.legalinfo.mn цахим хуудас/-нд ажлын нэг өдөрт багтаан байршуулж, энэхүү журмын 2.5.1-д заасны дагуу "Хууль зүйн мэдээлэл" сэтгүүлд нийтлүүлнэ.

6.6. Энэ журмын 6.1-д заасан этгээд нь шийдвэрийн улсын нэгдсэн санд байгаа шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан, хүчингүй болсонд тооцсон шийдвэрийг энэ журамд заасан хугацаанд хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.7. Улсын Их Хурлаас байгуулдаг байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гаргасан шийдвэрийн тухайд энэ журмын 2.4.7-д заасан нөхцөл байдал бий болсон бол хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ тухай Улсын Их Хурлын даргад танилцуулга хүргүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 123

Улаанбаатар
хот

Нийтлэг журам батлах тухай

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын 5.1.1, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Эрхлэх ажлынхаа хүрээний хөрөнгө оруулалтын төслийн судалгаа, үр ашгийн тооцоог үнэлж, ач холбогдлоор нь эрэмбэлэн жил бүрийн 2 дугаар сарын 5-ны дотор Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд хүргүүлж байхыг төслийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

3. Дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо /Ч.Хашчулуун/-нд даалгасугай.

3.1. энэхүү тогтоолын хавсралтаар баталсан журмын дагуу улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг 5 жилийн хугацаагаар жил бүр тодотгох зарчмаар боловсруулан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хамт 4 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

3.2. хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах, хянах, үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөх, сонгон шалгаруулах чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, яам, Засгийн газрын агентлаг, орон нутагт хөрөнгө оруулалтын асуудал хариуцан ажиллаж байгаа ажилтны чадавхийг дээшлүүлэх тодорхой хөтөлбөр боловсруулж, сургалт тогтмол зохион байгуулах.

4. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамрагдах төслийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, гүйцэтгэлийг хангахад шаардагдах мэдээлэл, тайланг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд гаргаж өгч байхыг бүх яам, Засгийн газрын агентлагт даалгаж, Монголбанк /Л.Пүрэвдорж/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/, Үндэсний аудитын газар /Ч.Раднаа/, Үндэсний статистикийн хороо /С.Мэндсайхан/-нд зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх гэрүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр жил бүр Үндсэн чиглэлд тусгах улсын төсөв, гадаадын зээл, тусламж, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, техник, технологийн шалтгалтын төсөл (цаашид "хөрөнгө оруулалтын төсөл" гэх)-ийг сонгох, төлөвлөх үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь Монгол Улсын хөгжлийн макро эдийн засгийн хүрээний болон бүсчилсэн хөгжлийн зорилт, салбаруудын хөгжлийн бодлогыг улсын төсөв, гадаадын зээл, тусламж, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх төслийг хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулан дунд хугацаа /5 жил/-ны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон хөрөнгө оруулалтын төслүүдийг нэгтгэн тооцсон цогц баримт бичиг байна.

1.3. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг таван жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдийг хамруулан боловсруулж Засгийн газраар батлуулна. Уг төслүүдийг жил бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх Үндсэн чиглэлтэй уялдуулан тодотгож байна.

1.4. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхдээ бэлтгэл хангах ажил (хайгуул судалгааны ажил, техник, эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө, зураг, төсөл боловсруулах) болон гүйцэтгэх үе шатны ажил гэж ангилна. Эдгээр үе шатанд тавигдах шаардлагыг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо холбогдох яам, Засгийн газрын агентлагтай хамтарч батална.

1.5. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах, хянах, үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөх, эдийн засгийн болон нийгмийн ач холбогдлоор нь төслүүдийг сонгон шалгаруулах гол үндэслэл болно.

1.6. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь Засгийн газраас улсын төсвөөр төлөвлөгөөний үндсэн дээр хөрөнгө оруулах, хувийн хөрөнгө оруулалтыг татах, дэд бүтцийн орчинг бүрдүүлэх, хандивлагч



орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг тохиролцох, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслийг тодорхойлох гол хэрэгсэл байна. Хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх үе шатны үйл ажиллагааг сонирхож талууд болон нийгэд ил тод мэдэрнэ.

Хоёр. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулахад тавигдах шаардлага

2.1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл болон тухайн жилийн Үндсэн чиглэлийн зорилтууд, төсвийн хүрээний мэдэгдэл, салбарын хөгжлийн бодлого, төсвийн чадаахи, эдийн засгийн шингээх чадвар, гадаад орийн зохистой харьцаа, улсын өрийн удирдлагатай нийцсэн байна.

2.2. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулахад хөрөнгийн эх үүсвэрийн дээрээс доош хандсан хуваарилалт, уг хуваарьт багтаан боловсруулсан доороос дээш чиглэсэн салбарын хөрөнгө оруулалтын хамгийн хэрэгцээтэй, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн төслийг сонгох, шалгаруулах зарнамд үндэслэсэн байна.

2.3. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийг боловсруулахад сум, дүүргээс эхлэн захиргааны байгууллагын шат бүхэнд тухайн төсөл бүрт бодлогын болон санхүү, эдийн засгийн шаокилгээ хийж дараагийн шатны байгууллагад шилжүүлнэ. Шаардлага хангаагүй төслийг дахин боловсруулах, баримт материал бүрдүүлэхээр дээд шатны байгууллага нь төсөл санаачлагчид буцаана.

2.4. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төсөл нь баримт бичгийн иж бүрдэл болон шаардлагыг хангасан, санхүү, эдийн засаг, нийгмийн үр ашигтай болох нь нотлогдсон байна.

2.5. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийн урсгал зардлыг тооцож, төсвийн хүрээний мэдэгдэл болон тухайн жилийн төсөвт тусгасан байна.

2.6. Хэндивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллага, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөлд Гадаад харилцааны яамны албан ёсны саналыг авна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжих хөрөнгө оруулалтын



төслийн төрөөс хүлээх үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцсон байна.

2.7. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах, үнэлэх, санхүүжүүлэх, тайлагнах, хяналт тавих, дүгнэх аргачлал, заавар, маягтыг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо холбогдох яам, эрх бүхий байгууллагатай хамтарч батлан мөрдүүлнэ.

2.8. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн эхний 3 жилийн хөрөнгө оруулалтын төсөл нь төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдсан байна.

Гурав. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах дараалал

3.1. Макро эдийн засгийн үзүүлэлтүүд, төсвийн хүрээний мэдэгдэл болон гадаад өрийн зохистой харьцаанд үндэслэн Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийн /улсын төсвийн болон эзэл, тусламж, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн хөрөнгийн эх үүсвэр/ нийт дунг Сангийн яамнаас тогтоож, жил бүрийн 11 дүгээр сарын 5-ны дотор Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд албан ёсоор хүргүүлсэн байна.

3.2. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо нь эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх дунд хугацааны бодлогыг үндэслэн салбар тус бүрээр нь эх үүсвэрийн хуваарилалт хийж, яам, Засгийн газрын агентлагаар нь хөрөнгө оруулалтын хязгаарыг тогтоож, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах удирдамжийг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо холбогдох байгууллагуудад жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор хүргүүлнэ.

3.3. Төсвийн ерөнхийлөн захирагч нь салбарынхаа хөгжлийн бодлогыг тодорхойлж, энэхүү журмын хоёрдугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгө оруулалтын төслийг боловсруулж, сайдын зөвлөлөөр хэлэлцүүлэн, хурлын тэмдэглэлийн хамт 2 дугаар сарын 5-ны дотор Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд хүргүүлнэ.

3.4. Төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын төслүүдийг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо салбар бүрээр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх дунд хугацааны бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн Үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан хянан нэгтгэж, ач холбогдлоор нь эрэмбэлэн яам,



Засгийн газрын агентлагийн удирдлагатай эцэслэн тохиролцож, жил бүрийн 4 дүгээр сард Засгийн газарт оруулж батлуулна.

3.5. Засгийн газраар баталсан тухайн санхүүгийн жилд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтыг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос Сангийн яаманд хүргүүлнэ.

3.6. Барилга байгууламжийн өргөтгөл, техник, технологийн шинэчлэлтээс бусад их засвар, угсрагдахгүй тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн бус машин, механизмын тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг төсвийн төсөлтэй уялдуулан Сангийн яам төлөвлөж хэрэгжүүлнэ.

Дөрөв. Холбогдох байгууллагуудын эрх, үүрэг

4.1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулахад Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо дараахь эрх, үүрэгтэй байна:

4.1.1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг тухайн жилийн адийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлтэй уялдуулан хянан нэгтгэх, хэлэлцүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, дүгнэх, тайлагнахтай холбоотой зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4.1.2. яам, Засгийн газрын агентлагаас дараа оны санхүүгийн жилийг оруулан 5 жилд хэрэгжүүлэхээр санал болгож байгаа хөрөнгө оруулалтын төслийг энэхүү журмын 2.7-д заасан аргачлал, зааврын дагуу сонгож төлөвлөх, үнэлэх, тэргүүлэх чиглэл, дарааллыг тогтоох, төслийн баримт бичиг болон тэдгээрийг боловсруулах даалгаврыг батлах;

4.1.3. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслүүдийг дотоод болон гадаад хөрөнгийн эх үүсвэртэй нягт уялдуулан Засгийн газраар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

4.1.4. яам, Засгийн газрын агентлагаас улирал бүр хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтийн талаар мэдээ, тайлан авч, явцтай нь танилцах замаар төслийн хэрэгжилтийг хагас жил тутам хэлэлцэж шаардлагатай арга хэмжээг хугацаа алдалгүй авахуулах зөвлөмж гаргах, улсын хөрөнгө оруулалтын мэдээллийн нэгдсэн сан байгуулж ажиллуулах;

4.1.5. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах заавар, аргачлал, удирдамж, гарын авлагыг боловсруулан баталж, яам, Засгийн газрын агентлаг, орон нутагт хүргүүлж мөрдүүлэх,



хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан боловсон хүчнийг сургаж, дадлагажуулах;

4.1.6. шаардлага хангаагүй, тооцоо судалгаа дутуу, иж бүрдэлгүй, хөрөнгийн хязгаартай уялдаагүй, тогтоосон хугацаанд ирүүлээгүй, хэрэгжих боломжгүй, цаашид үр ашиггүй нь нотлогдсон хөрөнгө оруулалтын төслийг төсөл санаачлагчид буцаах, хэрэгжилтийг зогсоох арга хэмжээ авах;

4.1.7. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төслийн хэрэгжилт, ажлын явц, чанарын талаар шаардлагатай гэж үзвэл тухайн төсөл, арга хэмжээг хариуцсан гүйцэтгэгч, захиалагч байгууллагын мэдээлэл, сонсголыг хэлэлцэх.

4.2. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулахад яам, Засгийн газрын агентлаг дараахь эрх, үүрэгтэй байна:

4.2.1. салбарын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаадын зээл, тусламж, төр-хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл нэг бүрийг энэхүү журмын 3.2-т заасан удирдамжийн дагуу боловсруулж, сайдын зөвлөлөөр хэлэлцэн хурлын тэмдэглэлийн хамт Үндэсний хөгжил, шилэтгэлийн хороонд хүргүүлэх.

4.2.2. улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын хүрээнд салбарын зорилго, зорилт, бодлогыг тодорхойлж, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт оруулах хөрөнгө оруулалтын төслийн саналыг боловсруулах;

4.2.3. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авах;

4.2.4. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай холбоотой мэдээ, тайланг зохих аргачлалын дагуу гаргаж, заасан хугацаанд нь Үндэсний хөгжил, шилэтгэлийн хороонд хүргүүлэх;

4.2.5. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт, ажлын явц, чанарын талаар тухайн төслийг хариуцсан гүйцэтгэгч, захиалагч байгууллагын мэдээлэл, сонсголыг улирал тутам хэлэлцэж холбогдох арга хэмжээ авах.

4.3 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхэд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага дараахь эрх, үүрэгтэй байна:



4.3.1 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийг аймаг, нийслэлийн Засаг дарга Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос хүргүүлсэн удирдамжийн дагуу боловсруулж, ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн холбогдох яам, Засгийн газрын агентлагт хүргүүлэх;

4.3.2. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн нарийвчилсан мэдээлэл, техник, эдийн засгийн үндэслэл, холбогдох тооцоо, судалгаа, танилцуулгыг нутаг дэвсгэрийнхээ байгууллагуудаас гаргуулан авах;

4.3.3. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт, түүний ажлын явц, чанарын талаар тухайн төсөл, арга хэмжээг хариуцсан гүйцэтгэгч, захиалагч байгууллагын мэдээлэл, сонсголыг хэлэлцрэх.

Тав. Бусад

5.1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөр батлагдсан тухайн жилийн хөрөнгө оруулалтын төсөлд хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, тайлагнах, гүйцэтгэл гаргах, мэдээлэх үүргийг төсвийн ерөнхийлөн захирагч нар хариуцна.

5.2. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, үйл ажиллагааг зөрчсөн төсвийн байгууллагын ерөнхий менежер болон бусад албан тушаалтанд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 65 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.3. Аймаг, нийслэл нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийг төлөвлөхдөө тухайн салбарын бодлого, чиглэл, мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг тусгасан байвал зохино.

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци,


Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 2.5

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тогмол Газрын Хэвлэл Хэсэгт хэвлэв.
Утас 329487